

**ДАРХЛААЖУУЛАЛТЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН
ТӨСӨЛД ХИЙСЭН ЗАРДЛЫН ТООЦООНЫ ТАЙЛАН**

2023 он

ДАРХЛААЖУУЛАЛТЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСӨЛД ХИЙСЭН ЗАРДЛЫН ТООЦОО

Дархлаажуулалтын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөлд Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын дөрөвдүгээр хавсралтаар баталсан “Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоог хийх аргачлал”-ын дагуу зардлын тооцоог хийлзээ.

Энэхүү үнэлгээний зорилго нь иргэн, хуулийн этгээд, төрийн байгууллагад үүсэх зардлын ачааллыг тооцож, цаашид гарах ачааллыг багасгах санал боловсруулахад оршино.

Уг аргачлалын Ерөнхий зүйлийн 1.5-д заасан журмын дагуу зардлыг төрийн байгууллагын зардал, хуулийн этгээдийн зардал, иргэнд үүсэх зардал гэсэн гурван төрлөөр тооцдог боловч тус хуулийн төслөөр хувь хүн, хуулийн этгээдэд бус төрийн байгууллагад тодорхой зардал үүсэхээр тусгасан байна.

Төрийн байгууллагын зардлыг тооцох

Зардлыг тооцоход дараах зарчмыг баримталсан болно:

- Бодит тоо баримт, мэдээлэлд тулгуурлах
- Аргачлалд заасан тооцоо хийх үе шатыг баримтлах

Хууль тогтоомжийн зохицуулалт

Дархлаажуулалтын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.2 дахь заалтад “заавал хийх дархлаажуулалт” гэж дархлаажуулах насын бүх хүнийг заавал хамарвал зохих дархлаажуулалтыг, 10 дугаар зүйлийн 10.1 дэх хэсэгт “Заавал хийх дархлаажуулалтад сүрьеэ, халдварт саа /полиомиелит/, В вируст гепатит, сахуу, хөхүүл ханиад, татран, улаанбурхан, В хэв шинжийн хемофилиюс инфлюенза нянгийн халдвар, гахай хавдар, улаануудын эсрэг сэргийлэх тарилга орно” гэсэн зохицуулалт байсан. Дархлаажуулалтын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслөөр “А вируст гепатит, пневмококк, хүний папиллома вирусийн халдварын эсрэг” гэсэн 3 төрлийн вакцин нэмэлтээр орж байгаа бөгөөд одоогийн байгаа зардлын хязгаарт багтаан үйл ажиллагаагаа оновчтой зохион байгуулах боломжтой улсын төсөвт шинээр нэмэлт ачаалал үүсгэхгүй. Хуулийн төсөлд нэмэлтээр тусгагдсан дархлаажуулах арга хэмжээг хэрэгжүүлэхэд тогтолцоо, бүтэц, нэгжийг шинээр зохион байгуулах шаардлагагүй.

Ажил, үйлчилгээг гүйцэтгэх хүний нөөцийг тодорхойлох

Хуулийн төсөлд нэмэлтээр тусгагдсан дархлаажуулах арга хэмжээг хэрэгжүүлэхэд тогтолцоо, бүтэц, нэгжийг шинээр зохион байгуулах шаардлагагүй бөгөөд үүнтэй холбоотой бүтэц, хүний нөөц, ажил үйлчилгээ гүйцэтгэхтэй холбоотой үйл ажиллагааны зардал гарахгүй.

А вируст гепатит, пневмококк, хүний папиллома вирусийн халдварын эсрэг вакцин нэмэлтээр заавал хийх дархлаажуулалтад оруулахтай холбоотой гарах зардалыг тооцоолсон.

Дархлаажуулалтын тухай хуульд нэмэлт оруулахад шаардагдах төсөв

Вакцины нэр	Хамрагдвал зохих хүүхдийн тоо	Вакцины тоо	Вакцины нэгжийн үнэ	Тариур, аюулгүй хайрцагны үнэ /төгрөг/	Нийт зардал /төгрөг/	
					100 % хамрагдах үед	95 % хамрагдах үед
А вируст гепатитын эсрэг вакцин	63 954	140 699	25 980	14 491 976.4	4 255 411 287.2	4 042 640 722.8
Пневмококкийн эсрэг вакцин	70 663	233 188	12 542	16 012 235.8	3 433 444 648.3	3 261 772 415.9
Хүний папиллома вирусийн халдвартын эсрэг вакцин	63 694	70 063	18 369	14 433 060.4	1 503 148 941.5	1 427 991 494.4
Нийт					9 192 004 877.0	8 732 404 633.2

Зардлыг нэгтгэн тооцох

Монгол Улсын 2023 оны Төсвийн тухай хуулиар батлагдсан Эрүүл мэндийн сайдын багцын вакцин биобэлдмэл, зүү тариурын төсөв 23 тэрбум төгрөг байхаар тусгагдсан. А вируст гепатитын эсрэг вакциныг 2011 оноос, Пневмококкийн эсрэг вакциныг 2016 оноос нэвтрүүлсэн ба 2023 оноос нэвтрүүлж эхлэх хүний папиллома вирусийн халдвартын эсрэг вакциныг одоогийн байгаа төсвийн хязгаарт багтаан зохион байгуулах боломжтой.

Нийт зардал = 9.1 тэрбум төгрөг

Хувилбарыг нягталж, үр дүнг танилцуулах

Хууль хэрэгжсэнээр урт хугацаанд эрүүл мэндийн салбарын зардал буурах, халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, нийтийн эрүүл мэнд сайжрах боломжтой.

---оОо---